



**Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал**


Зураг 5

Монгол Улсад 2010 оны эхний хагас жилд гадаадын 82 орны 14.2 мян.иргэн хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5 орноор цөөрч, ажиллагчдын тоо 25.6 хувиар буурчээ. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч гадаадын иргэдийн 93.0 хувь нь эрэгтэйчүүд байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт ажиллагчдын 75.4 хувь нь БНХАУ-ын, 4.6 хувь нь ОХУ-ын, 3.1 хувь нь БНСУ-ын, 2.8 хувь нь БНАСАУ-ын, 2.3 хувь нь АНУ-ын, 1.4 хувь нь Япон улсын, 1.3 хувь нь Вьетнам улсын, 1.1 хувь нь Австрали улсын, 0.9 хувь Канад улсын, 0.6 хувь нь ХБНГУ-ын, 6.5 хувь нь бусад улсын харьяат иргэд байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад манай улсад хөдөлмөр эрхэлж буй иргэдийг улсаар нь ав+ үзвэл Австрали улсынх 2.3 дахин, Канад улсынх 96.8 хувь, Япон улсынх 86.0 хувь, БНАСАУ-ынх 47.2 хувь, Вьетнам улсынх 32.4 хувь, ХБНГУ-ынх 32.4 хувиар тус тус өс+, харин ОХУ-ынх 39.3 хувь, БНХАУ-ынх 26.6 хувь, БНСУ-ынх 23.8 хувь, АНУ-ынх 12.6 хувь, бусад улсынх 47.4 хувиар тус тус буур+ээ.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн 5481 нь уул уурхай, олборлох, аж үйлдвэрийн, 3692 нь барилгын, 1732 нь тээвэр, агуулахын аж ахуй, холбооны, 721 нь бөөний болон жижиглэн худалдааны, 696 нь боловсролын, 474 нь боловсруулах аж үйлдвэрийн, 810 нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

**Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт,эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2010 оны эхний хагас жилийн байдлаар**



Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр